

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН ХӨТӨЛБӨРӨӨР ТӨГСӨГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Ариунжаргал Ө¹, Оюунцэцэг С¹, Цэрэндагва Д²

¹АШУУИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

¹АШУУИС, Бuo Анагаахын Сургууль

²АШУУИС, МАУОУС, Дотор өвчин судлалын тэнхим

Цахим шуудан: ariunjargal.u@mnumns.edu.mn

Үндэслэл: Дэлхийн даяарчлалын онцлогоос шалтгаалан сургалтын зорилго, агуулга, арга зүйн талаар уламжлалт сэтгэлгээ өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл тухайн сургалтын үр дүн ямар байх нь уг хичээлийн зорилго, үйл явц болон хэрэглэгчийн шаардлага, эрэлт хэрэгцээ, сонирхолтой хэрхэн нийцэж байгаагаас хамаарч байна. Анагаах ухааны боловсрол олгох сургалтын байгууллагаар суралцаж төгсөгчдийн сэтгэл ханамжийн түвшин (3.2) байна. Уламжлалт Анагаах Ухаан хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлсноор хөтөлбөрт оролцогч талууд болон хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид сургалтын хөтөлбөрийг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж боловсронгуй болгох боломжтой.

Зорилго: Уламжлалт анагаах ухаан хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлж, харьцуулан судлах

Зорилт: Төгсөгчдийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлэх

Аргачлал: Судалгааг дескриптив судалгааны агшингийн загвар, тоон судалгааны аргаар хийж гүйцэтгэсэн. Судалгаанд оролцогчдыг магадлалт түүвэрлэлтийн аргын энгийн санамсаргүй загварыг ашиглан төгсөгчдөөс нээлттэй 10 асуулт бүхий асуумжаар Ликертийн 1-5 хүртэлх хэмжүүр ашиглан үнэлж, сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон. Судалгааг 2010 онд шинэчлэгдсэн хөтөлбөрөөр 2016-2019 оны хичээлийн жилүүдэд суралцаж төгссөн 62 төгсөгчдийг хамруулсан. Асуумжийн үнэн зөв байдлыг Cronbach-ийн α коэффициентээр задлан шинжилж, асуумжийн хүчин төгөлдөр байдлыг Judgment аргаар үнэлсэн.

Үрдүн: 1. Судалгаанаас 2010 онд шинэчлэгдсэн хөтөлбөрөөр суралцаж төгсөгчдийн сургалтын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээг сэтгэл ханамжийн түвшингээр илэрхийлбэл бүрэн сэтгэл ханамжтай 16.4%, сэтгэл ханамжтай 32.5%, дундаж 36%, сэтгэл ханамжгүй 13.4%, огт сэтгэл ханамжгүй 6.4% буюу дундаж үнэлгээ 3.36, буюу шинэчлэн боловсруулсан 2+4 хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдийн сэтгэл ханамжийн түвшин 3.57 байгаа нь дундаас дээш байна. Судалгаанд оролцогч

62 төгсөгчдөөс мэргэжлээрээ одоо ажиллаж байна уу гэсэн асуултанд 74.2% ажиллаж байгаа, мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаанаа тодруулна уу гэсэн асуултанд мэргэжлийн ажлын байр олдохгүйгээс, цалин бага, үндсэн мэргэшлээр суралцах, магистрын сургалтанд хамрагдах зэрэг шалтгаануудыг дурдсан байна. Суралцаж байх хугацаандаа нийгмийн харилцааны чадваруудаас хэр зэрэг эзэмшсэн, цаашид хөтөлбөрийн агуулгад байх шаардлагатай гэж үзэж байна уу гэсэн асуултанд 88.2% нь шаардлагатай тухайлбал багаар ажиллах, мэдээлэл солилцох, гадаад хэл дээр харьцах зэрэг чадваруудыг дундаж буюу 3.06 гэсэн байна.

Судалж байсан хичээлүүдийн дотор сэдэв агуулгын давхардал хэр зэрэг байсан талаарх асуултанд 30.9% нь сэдэв агуулгын давхардал байсан гэж хариулсан байна.

Дүгнэлт: Уламжлалт анагаах ухаан хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамж (3.36) байна. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сэдэв, агуулгын давхардлыг багасгах боломжтой.

Түлхүүр үг: Уламжлалт анагаах ухаан, сэтгэл ханамж, төгсөгчид